



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 30 (167)

Монгол Улсын Хууль:

- *Засгийн газрын бүтцийн тухай*
- *Засгийн газрын бүрэлдэхүүний тухай*

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- *Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын талаар авах зарим арга хэтжээний тухай*
- *Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэтжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны наймдугаар сарын 11

№30 (167)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|---|----------------------|-----|
| 314. Засгийн газрын бүтцийн тухай | (2000-8-3-ны хууль) | 542 |
| 315. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай | (2000-8-3-ны хууль) | 542 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|--|------------|-----|
| 316. Сахариягийн Даржаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 115 | 542 |
| 317. Жумабайн Жүнист Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 116 | 543 |
| 318. Баян-Өлгий аймгийн зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 117 | 543 |
| 319. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилх тухай | Дугаар 118 | 545 |
| 320. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 119 | 545 |
| 321. Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай | Дугаар 120 | 545 |
| 322. Пунсалын Дайрийжавт Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай | Дугаар 121 | 546 |
| 323. Зарим хүнийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай | Дугаар 122 | 546 |

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | |
|---|------------|-----|
| 324. ЖУрам шинэчлэн батлах тухай | Дугаар 96 | 546 |
| 325. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг тогтоох тухай | Дугаар 97 | 552 |
| 326. Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 98 | 553 |
| 327. Орон сууц хувьчлах тухай | Дугаар 99 | 553 |
| 328. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 101 | 554 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 8 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүтцэд дор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн:

- 1/Гадаад хэргийн яам;
- 2/Санхүү, эдийн засгийн яам;
- 3/Хууль зүй, дотоод хэргийн яам.

Чиглэлийн:

- 4/Байгаль орчны яам;
- 5/Батлан хамгаалах яам;

- 6/Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам;
- 7/Дэд бүтцийн яам;
- 8/Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам;
- 9/Үйлдвэр, худалдааны яам;
- 10/Хүнс, хөдөө аж ахуйн яам;
- 11/Эрүүл мэндийн яам.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2000 оны 8 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 8 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар тогтоосугай:

- 1/Монгол Улсын Ерөнхий сайд;
- 2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Байгаль орчны сайд;
- 3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Батлан хамгаалахын сайд;
- 4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;
- 5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Гадаад хэргийн сайд;
- 6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Дэд бүтцийн сайд;
- 7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд;
- 8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Санхүү, эдийн засгийн сайд;
- 9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Үйлдвэр, худалдааны сайд;

- 10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Хууль зүй, дотоод хэргийн сайд;
- 11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Хүнс, хөдөө аж ахуйн сайд;
- 12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Эрүүл мэндийн сайд;
- 13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай 1996 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2000 оны 8 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Сахариягийн Даржаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд тооны ухааны хичээл олон жил зааж, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, сурагчдын математик сэтгэлгээг хөгжүүлэх, өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баян-Өлгий аймгийн Өлгий

сумын 10 жилийн нэгдүгээр сургуулийн багш Сахариягийн Даржаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

Жумабайн Жүнист Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж нийслэл, аймгийн төвөөс алслагдсан хөдөөгийн хөдөлмөрчдөд мэс заслын болон эмнэлгийн бусад нарийн мэргэжлийн тусламж шуурхай хүргэж, хүн ардыг эмчлэн эдгэрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баян-Өлгий аймгийн Булган сумын

хүний эмнэлгийн салбарын эрхлэгч их эмч Жумабайн Жүнист Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

Баян-Өлгий аймгийн зарим иргэнийг одон, медалиар шагнах тухай

Баян-Өлгий аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, эрүүл мэндийн салбар болон цагдаа, шүүх, гааль, төрийн захиргаа, төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг тус аймаг байгуулагдсаны 60 жилийн ойг тохиолдуулан одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Сергазбайн Алипхан
2. Асимын Амен
3. Сейтжэвэгийн Жалел

4. Шаруганы Жанузэг
5. Мухайсын Зейнелхан
6. Насангийн Равдаа
7. Ахмадийн Сайндолда

8. Асханбайн Сарай
9. Хыдыржаны Султанхан
10. Сарбасын Харжаубай

11. Орынбайн Хатран
12. Огноогийн Цэрэв

- Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл
- Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын иргэн, ахмад агрономч
- Баян-Өлгий аймгийн үйлдвэрлэл, худалдааны "Азыг" ХК-ийн гүйцэтгэх захирал
- Баян-Өлгий аймгийн Радио нэвтрүүлгийн редакцийн нэвтрүүлэгч
- Монголбанкны Баян-Өлгий аймаг дахь салбарын захирал
- Баян-Өлгий аймгийн Хянан шалгах хорооны ахлах байцаагч
- Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн байцаагч
- Төр, захиргааны байгууллагын ахмад ажилтан
- Баян-Өлгий аймгийн "Эрчим" ХК-ийн захирал
- Баян-Өлгий аймгийн барилга угсралтын "Мөхөнжай" ХК-ийн захирал
- Баян-Өлгий аймгийн Хөдөө аж ахуйн газрын мал зүйч
- Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. ИКадены Ахрас
2. Төмөрийн Баянбаа
3. Шамкейн Бирдай
4. Төкөшийн Галбаа
5. Мямбарын Жамсран
6. Равсалын Заан
7. Зияяданы Кенган
8. Жакейн Мизамхан

- Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
- Баян-Өлгий аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газры жолооч
- Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын ерөнхий нягтлан бодогч
- Баян-Өлгий аймгийн Холбооны газрын албаны дарга
- Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга
- Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын хүний эмнэлгийн салбарын их эмч
- Баян-Өлгий аймгийн "Эрчим" ХК-ийн инженер
- Баян-Өлгий аймгийн Хянан шалгах хорооны дарга

- | | |
|------------------------------|--|
| 9. Кунтуганы Мизамхан | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан |
| 10. Балжирын Номт | -Баян-Өлгий аймгийн тээвэр, үйлчилгээний "Тулпар" ХК-ийн жолооч |
| 11. Бакейн Сукай | -Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын багийн Засаг дарга |
| 12. Хауметбайн Тау | -Баян-Өлгий аймгийн Мэгэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал |
| 13. Төлеубайн Тогтархан | -Баян-Өлгий аймгийн Толбо сумын Засаг дарга |
| 14. Рамишийн Төхөй | -Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын иргэн, ахмад багш |
| 15. Елеукейн Хавал | -Баян-Өлгий аймгийн Толбо сумын иргэн, төр захиргааны байгууллагын ахмад ажилтан |
| 16. Сакейн Хавал | -Баян-Өлгий аймгийн үйлдвэр, худалдааны "Автотранс" ХХК-ийн захирал |
| 17. Зияаданы Хаядыл | -Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 3 дугаар багийн Засаг дарга |
| 18. Мүбаракийн Хадьс | -Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн эрхлэгч |
| 19. Аххожагийн Хажнаби | -Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрын хөгжимчин |
| 20. Таукейн Халифа | -Баян-Өлгий аймгийн Өлгий сумын хувиараа хөдөлмөр эрхлэгч |
| 21. Абдгажийн Халкен | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл |
| 22. Цэрэнчимэдийн Цагаанцоож | -Баян-Өлгий аймгийн Цагааннуур сумын Улаанбайшин дахь Гаалийн салбарын эрхлэгч |
| 23. Тайфын Шаруан | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч |
| 24. Зайтений Шерхан | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын албаны дарга |
| 25. Толгатбекийн Шия | -Баян-Өлгий аймгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн "Алатау" ХК-ийн захирал |
| 26. Табаракийн Шөндөй | -Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл |
| 27. Ойровын Шуураа | -Хадгаламжийн банкны Баян-Өлгий аймаг дахь салбарын эдийн засагч |

ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОНГООР:

- | | |
|------------------|---|
| Тумысханы Костёр | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга |
|------------------|---|

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- | | |
|---------------------------|---|
| 1. Тахаугийн Ашим | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх татварын хэлтсийн татварын улсын байцаагч |
| 2. Онхайн Байгадар | -Баян-Өлгий аймгийн Сагсай сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч |
| 3. Закариягийн Будий | -Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Засаг дарга |
| 4. Халманийн Бийк | -Баян-Өлгий аймгийн Алтай сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч |
| 5. Сагидолдагийн Газиза | -Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 1 дүгээр дунд сургуулийн үйлчлэх хөдөлмөрийн багш |
| 6. Ахтышханы Гүлнар | -Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын өрхийн их эмч |
| 7. Ахбиегийн Күлша | -Баян-Өлгий аймгийн Холбооны газрын залгагч |
| 8. Бозайн Марзия | -Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын их эмч |
| 9. Бахыткеримийн Мизамхан | -Баян-Өлгий аймгийн Бугат сумын Засаг даргын Тамгын газрын татварын улсын байцаагч |
| 10. Туртайн Мизанай | -Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл |
| 11. Хахарманы Минат | -Баян-Өлгий аймгийн Толбо сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан |
| 12. Омаргажийн Монголхан | -Баян-Өлгий аймгийн радио өргөн нэвтрүүлэх станцын инженер |
| 13. Самалханы Муталив | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан |
| 14. Камелханы Нургайв | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн |
| 15. Жаманы Нурсолтан | -Баян-Өлгий аймгийн Холбооны газрын залгагч |
| 16. Сабийн Оралгон | -Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 3 дугаар дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш |
| 17. Алахайн Рахадьл | -Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын газар тариалангийн "Толхын" хоршооны эзэн |
| 18. Хаугажайн Самидан | -Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын 6 дугаар багийн Засаг дарга |



- | | |
|------------------------|---|
| 19. Жаукөрханы Самихан | -Баян-Өлгий аймгийн Булган сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл |
| 20. Асылханы Сауле | -Баян-Өлгий аймгийн шүүхийн шүүгч |
| 21. Саррахбайн Сөйлхан | -Баян-Өлгий аймгийн нийтийн аж ахуй, үйлчилгээний "Суат" ХХК-ийн жолооч |
| 22. Базарын Турсынхан | -Баян-Өлгий аймгийн Ногоонуур сумын Ховд багийн хүний бага эмч |
| 23. Сахариягийн Уакил | -Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан |
| 24. Якиягийн Хадий | -Баян-Өлгий аймгийн Цагааннуур сумын холбооны салбарын эрхлэгч |
| 25. Төлөвугийн Цэнгэл | -Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын хүний эмнэлгийн сувилагч |

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

- | | |
|-------------------------|--|
| 1. Жажекеберийн Онтуган | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн хэлтсийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч |
| 2. Муссагийн Өмирбек | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн хэлтсийн төлөөлөгч, цагдаагийн хошууч |
| 3. Жумаржаны Сейл | -Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн хэлтсийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Дагвадоржийн Мөнхтуяаг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Доржпалламын Сугарыг Сүхбаатар аймаг дахь сум

дундын шүүхийн шүүгчийн, Чимэдбалдирын Баасанжавыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай хууль"-ийн 51 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүсэлт гаргасан Бодьгэрэлийн Бямбаэсүрэнг Архангай аймаг дахь сум дундын

шүүхийн шүүгч, Банзрагчийн Сайнбаярыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай хууль"-ийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Эрүүгүйн байцаан шийтгэх ажиллагаанд дутагдал гаргасан, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг

ноцтой зөрчсөн Цогбадрахын Мөнхтүвшин, Чадраабалын Эрдэнэ-Очир нарыг Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус огцруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

Пунсалын Дайрийжавт Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай

Прокурорын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаанд тавих хяналтын арга хэлбэрийг боловсронгуй болгох, хууль ёсыг бэхжүүлэх, залуу боловсон хүчнийг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор Пунсалын Дайрийжавт Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 7 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Зарим хүнийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Хуулийн болон аж ахуйн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

1. Монголын Алтанхуяг
2. Элдэвийн Бадам
3. Бүрэнтөгсийн Галдаа
4. Намсрайжавын Зоригт

-Улсын ерөнхий прокурор
 -Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга
 -Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор
 -Улс хоорондын тээврийн зууч "Туушин" ХХК-ийн ерөнхий захирал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Боловсролын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэх журам"-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталж 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Сургалтын төлбөрийн зээл, тусламжийг 2000 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн төвлөрүүлэн зарцуулж байхыг Сургалтын төрийн сангийн захирал Б.Ганбатад даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам, дүрэм батлах тухай" Засгийн газрын 1997 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 179 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Гэгээрлийн сайд

А.БАТТӨР



Засгийн газрын 2000 оны 96 дугаар
тогтоолын хавсралт

ИХ СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД СУРАЛЦАГЧДАД СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ЗЭЭЛ, БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ, ЭРГЭЖ ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг зүйл

1.Боловсролын хуулийн дагуу магадлан итгэмжлэгдсэн их сургууль, коллежийн оюутан, магистрант, докторант, Засгийн газрын гэрээ, хэлэлцээрээр гадаадад суралцагчид (цаашид "суралцагч" гэнэ) сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох, эргэж төлүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

Энэхүү журам нь Засгийн газрын гэрээ, хэлэлцээрээр гадаад улсад суралцуулагч талын зардлаар 6 сар хүртэл хугацаагаар мэргэшүүлэх сургалтад суралцагчдад нэгэн адил жамаарна.

2.Боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран сургалтын төлбөрийн зээл болон буцалтгүй тусламжаар суралцах суралцагчдын хяналтын тоог жил бүрийн 5 дугаар сард мэргэжил тус бүрээр нь батлан гаргана.

3.Дээд боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгж нь кредит цаг байна. Нэг кредит цаг нь улирлын туршид нэг долоо

хоногт танхимд нэг цагаар орох лекц буюу 2 цагаар орох семинар, дадлага, эсвэл 3 цагаар орох лабораторын ажлын нийт цагтай тэнцүү тоон утгаар хэмжигдэнэ.

4.Их сургууль, коллеж нь суралцагчдын кредит цагийн өртгийг үндэслэн тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг сургуулийн Удирдах зөвлөлийн хурлаар батлуулж 6 дугаар сард нийтэд зарлана.

5.Суралцагчдын улирлын болон суралцсан хугацааны агуулга эзэмшилтийн чанарын түвшинг тогтооход голч дүнг ашиглана. Голч дүн нь дээрх хугацаанд үзсэн хичээлд авсан тоон дүнгийн кредит цагаар жигнэгдсэн дундаж байна.

6.Сургалтын төлбөрийн хөрөнгийг төвлөрүүлэн бүрдүүлэх, зээлийн гэрээг баталгаажуулах, сургалтын зээл олгох, буцааж төлүүлэх, буцалтгүй тусламж өгөх, шаардлагатай бол шүүхэд нэхэмжлэл гаргах, санхүүгийн тайлан гаргах үүргийг Сургалтын төрийн сан хариуцна.

Хоёр.Их сургууль, коллежид сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж, шагнаалаар суралцуулах нөхцөл

7.Их сургууль, коллежид зохих журмын дагуу шинээр элсэн суралцагч болон амжилттай суралцаж байгаа суралцагчдад дор дурдсан нөхцөлөөр сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж, шагнал олгоно:

а/сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл:

-Үндэсний статистикийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрх, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй өрх, эцэг, эх нь хоёулаа өндөр насны тэтгэвэрт байгаа өрхийн суралцагч;

-Үндэсний статистикийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хагас өнчин суралцагч;

-их сургууль, коллежийг бакалаврын боловсролоор 3,5-аас дээш голч дүнтэй төгссөн, магистрантур, докторантурт суралцагч;

-Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад оронд суралцагч.

б/сургалтын төлбөр, тэтгэлэгийн буцалтгүй тусламж:

-бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, нэн ядуу өрхийн тахир дутуу суралцагч;

в/сургалтын төлбөрийн шагнал:

-олон улсын хэмжээнд зохиогдсон олимпиад, олон улсын дээд зэрэглэлийн уралдаан, тэмцээнд шагналт байр эзэлсэн суралцагч;

-ерөнхий боловсролын сургуулийг төгсөх жилдээ улсын хэмжээнд зохиогддог

олимпиадад эхний 3 байр эзэлсэн суралцагч; -их сургууль, коллежид дараалсан 4 улиралд голч дүнгээрээ 3,8 буюу түүнээс дээш амжилт үзүүлсэн, суралцах хугацаандаа зохих кредит цагийг бүрэн биелүүлсэн суралцагч.

Гурав.Сургалтын төлбөрийн зээл, тусламжийн гэрээ байгуулах, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

8.Тухайн хичээлийн жилд суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, тусламж олгох асуудлыг хяналтын тоонд багтаан шийдвэрлэж байх үүрэг бүхий 5-аас доошгүй хүнтэй комиссыг их сургууль, коллежийн захирлын тушаалаар байгуулж ажиллуулна. Уг комисс нь сургалтын алба, нягтлан бодогч, оюутны байгууллага, эцэг, эхийн төлөөллөөс бүрдэнэ.Комиссоос гарсан шийдвэрийг үндэслэн сургалтын алба энэхүү журмын дагуу сургалтын төлбөрийн зээл, тусламжийн гэрээг Сургалтын төрийн сан, суралцагчтай байгуулж, уг гэрээг сунгах буюу цуцлах ажлыг зохион байгуулна.

9.Гэрээг их сургууль, коллежид сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжаар суралцагч (эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч), Сургалтын төрийн сан, сургалтын албаны хооронд гурвалсан хэлбэрээр байгуулж, нотариатаар гэрчилнэ.

10.Төрийн захиргааны ба үйлчилгээний байгууллага (цаашид "захиалагч" гэнэ)-ын захиалгаар Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад оронд суралцагч болон тус улсын их сургууль, коллежийн магистрантур, докторантурт суралцагч нь тэдгээрийг суралцуулагч байгууллага, Сургалтын төрийн сантай гурвалсан хэлбэрээр гэрээ байгуулж, нотариатаар гэрчилнэ.

11.Сургалтын төрийн сан нь хичээлийн жилийн улирал тутамд суралцагчийн сурлагын талаар сургуулиудаас ирүүлсэн тодорхойлолт болон боловсролын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан голч дүнг харгалзан зээл, тусламжийн гэрээг сунгаж баталгаажуулна.

12.Их сургууль, коллежийн нягтлан бодогч суралцагчийн авсан зээл, тусламжийг зээлийн гэрээ, картад бичилт хийн тухайн хичээлийн жилийн улирал бүрийн эцэст Сургалтын төрийн сантай тооцоо нийлж гурвалсан гэрээний сунгалт болон төгсөгчдийн төлбөрийн хаалт хийнэ.

13.Тус улсын их сургууль, коллежид сургалтын төлбөрийн зээл, тусламжийн гэрээгээр суралцагч Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр гадаадад шилжин суралцах үед түүний Сургалтын төрийн санд төлөгдөх сургалтын төлбөрийг зээлээр үргэлжлүүлэн олгож болно.

14.Сургалтын төрийн сан, сургууль, суралцагчийн хооронд байгуулах гэрээнд сургалтын төлбөрийн зээл, тусламж олгох, эргэж төлүүлэх талаар талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгана.

15.Сургалтын төрийн сан, захиалагч, суралцагчийн хооронд байгуулах гэрээнд тухайн суралцагчийн суралцах хугацаа, түүний ажлын байр болон сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлүүлэх талаар талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгана.

16.Сургалтын төлбөрийн зээл, тусламжийн гэрээний загварыг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.



Дөрөв.Сургалтын төлбөрийн зээл, тусламж авахад суралцагчийн бүрдүүлэх материал

17.Сургалтын төлбөрийн зээл болон буцалтгүй тусламж авахдаа суралцагч дарваажь материалыг бүрдүүлнэ:

а/их сургууль, коллежид элссэнийг нотлож элсэлтийн төв комиссоос олгосон томилолт; магистрантур, докторантурт суралцуулах тухай сургуулийн шийдвэр; Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр гадаадын их сургуульд суралцуулах тухай боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;

б/сургалтын төлбөрийн зээл, тусламж хүссэн болон түүнийг буцааж төлөх тухай нотолсон суралцагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гараар бичсэн өргөдөл;

в/иргэний үнэмлэхийн хуулбар;

г/энэхүү журмын 7-гийн "б"-д заасан суралцагчийн хувьд эцэг, эх, асран хамгаалагч нь нас барсан тухай гэрчилгээний хуулбар;

д/зээлийн төлбөрийн хөрөнгийн баталгааны нотариатын гэрчилгээ;

е/Үндэсний статистикийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу өрх болох тухай (Улаанбаатар хотоос суралцагчийн хувьд харьяалах хорооны дарга, дүүргийн Засаг даргын Тамгын газрын, орон нутгаас суралцагчийн хувьд сумын болон аймгийн Засаг даргын Тамгын газрын) тодорхойлолт;

ж/энэ журмын 7-гийн "а"-д заасан суралцагчийн өрхийн гишүүдийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, тахир дутуу болохыг тогтоосон холбогдох байгууллагын шийдвэр;

з/энэ журмын 7-гийн "б"-д заасан суралцагчийн тахир дутуу болохыг тогтоосон холбогдох байгууллагын шийдвэр;

и/итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тухай нотариатын гэрчилгээний хуулбар.

Тав.Сургалтын төлбөрийн зээл, тусламжийг санхүүжүүлэх, түүнийг зогсоох

18.Сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжаар суралцагчдад шаардагдах хөрөнгийг жил бүрийн төвлөрсөн төсөвт тусгана. Төсвийг төлөвлөхдөө өмнө нь олгосон зээл, түүний хүүгийн төлбөрийн орлогыг оруулж тооцно.

19.Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургалтын төлбөрийн зээл, тусламжийн хөрөнгийг тухайн жилийн улирал тутам Сургалтын төрийн санд шилжүүлнэ.

20.Сургалтын төлбөрийн зээл, тусламжаар суралцагчдын төлбөрийг төрийн өмчийн их сургууль, коллежийн нийтэд зарласан сургалтын төлбөрийн жишиг, кредит цагийн биелэлтээр Сургалтын төрийн сангаас батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлнэ.

21.Үндэсний статистикийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих түвшин-

гээс доогуур орлоготой өрхийн хагас өнчин оюутанд хичээлийн жил тутмын сургалтын төлбөрийн 150000 төгрөгийг буцалтгүй тусламж хэлбэрээр, үлдэх төлбөрийг нь зээлийн гэрээгээр олгоно.

22.Бүтэн өнчин, асран хамгаалагчгүй, тахир дутуу бөгөөд дипломын болон бакалаврын боловсрол эзэмшихээр суралцагчдад сургалтын төлбөр болон тэтгэлгийг буцалтгүй тусламж хэлбэрээр гэрээгээр олгоно. Тэтгэлгийн хэмжээг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

23. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр доорхи болзлыг хангасан суралцагчдын сургалтын төлбөрийг шагналын хэлбэрээр Сургалтын төрийн сангаас санхүүжүүлнэ.



а/олон улсын хэмжээнд зохиогдсон олимпиад болон олон улсын зэрэглэлтэй уралдаан, тэмцээнд шагналт байр эзэлсэн их сургууль, коллежид бакалаврын боловсрол эзэмшихээр суралцагчдад сургалтын хөтөлбөрийн агуулгыг эзэмших хугацаанд;

б/өрөнхий боловсролын сургуулийг төгсөх жилдээ улсын хэмжээнд зохиогдсон олимпиадад эхний 3 байр эзэлж уг чиглэлээрээ их сургууль, коллежид элсэн суралцагчдад эхний 2 жилд;

в/суралцсан хугацаандаа авбал зохих кредит цагийг бүрэн биелүүлж, дараалсан 4 улирлын голч дүн нь 3,8-аас дээш амжилт үзүүлсэн оюутанд энэхүү хугацаанд;

г/суралцсан хугацаандаа авбал зохих кредит цагийг бүрэн биелүүлж, эхний жилийн голч дүнгээрээ 3,8-аас дээш амжилт үзүүлсэн болон тухайн сургууль, их сургууль, коллежийн хэмжээнд зохиогдсон эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж, шилдэг бүтээлээр шалгарсан магистрант, эрдэм шинжилгээний тодорхой хэсэг нь үйлдвэрлэлд нэвтэрч үр дүн нь гарч байгаа докторантад хамгаалах хүртэлх хугацаанд.

24.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр суралцагчдад тэтгэлэг олгохгүй тохиолдолд боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тэтгэлгийн хэмжээг тогтоож түүнийг зээлээр олгоно. Сургалтын төрийн сан зээлийн тэтгэлгээр

суралцаж буй суралцагчдын санхүүжилтийг улирал тутам тухайн оронд суугаа Элчин сайдын яамдаар дамжуулан олгож, түүний тайланг улирал тутам гаргуулна.

25.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр гадаад орноос тус улсын их сургууль, коллежид суралцагчдад сургалтын төлбөр болон тэтгэлгийг Сургалтын төрийн сангаас хуваарийн дагуу санхүүжүүлнэ. Боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран сургалтын төлбөр, тэтгэлгийн хэмжээг тогтооно.

26.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр суралцагчийн сурлагын байдлын талаархи сургуулийн тодорхойлолтыг үндэслэн Сургалтын төрийн сангаас дараа жилийн сургалтын болон тэтгэлгийн гэрээг сунгаж зээлийг санхүүжүүлнэ.

27.Энэхүү журмын 7-гийн "а", "б"-д заасны дагуу сургалтын төлбөрийн зээл, тусламжаар сурч байгаад Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрээр гадаад оронд бакалаврын боловсролоор шилжин суралцагчдад сургуульдаа анх очих, төгсөөд бүрмөсөн ирэх замын зардлын зээл олгож болно.

28.Суралцагч хүүхэд төрүүлсэн болон бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар зохих журмын дагуу чөлөө авсан бол зээлийн гэрээг түдгэлзүүлэн сургалтын төлбөр, тэтгэлгийн санхүүжилтийг түр зогсооно.

Зургаа.Сургалтын төлбөрийн зээлийг төлүүлэх, барагдуулах тухай

29.Сургалтын төлбөрийн зээл, тусламжаар суралцагч сургуулиа төгссөн, эсхүл гэрээлэгч талуудын аль нэг нь гэрээг цуцалсан буюу түдгэлзүүлсэн бол тухайн суралцагчийг сургаж буй сургуулиас энэ тухай Сургалтын төрийн санд ажлын 10 өдрийн дотор албан ёсоор мэдэгдэнэ.

30.Сургалтын төлбөрийн зээлээр суралцагч сургуулиас хасагдсан, сургуулиа орхисон тохиолдолд тухайн сургууль нь Сургалтын төрийн санд ажлын 5 өдрийн дотор энэ тухай албан ёсоор мэдэгдэнэ. Хэрэв энэ тухай мэдэгдээгүй бол тухайн сургуулийн зээл, тусламжаар суралцагчийн дараа улирлын санхүүжилтээс суутгал хийнэ.

31.Энэхүү журмын 28-д зааснаас бусад шалтгаанаар суралцагч цаашид суралцахгүй болсон тохиолдолд сургалтын төлбөрийн зээл, тусламж, тэтгэлгийг зогсоож суралцахгүй болсон тухайн сараас эхлэн жилийн 3 хувийн хүүтэйгээр 2 жилийн дотор буцааж төлүүлнэ. Хүүгээс хүү тооцохгүй.

32.Сургалтын төрийн сан хичээлийн жилийн улирал тутам энэхүү журмын 11-д заасны дагуу сурлагын байдлын талаархи сургуулийн тодорхойлолтыг үндэслэн зээл, тусламжаар суралцагчийн гэрээг түдгэлзүүлж, дахин сэргээж болно.



33. Зээлээр суралцагч нь сургалтын хөтөлбөрийг бүрэн дуусмагц түүнийг төгссөгсөн сургууль зээлийн картанд зээлийн бичилтийг бүрэн хийж, уг суралцагчаар гарын үсэг зуруулан дипломын хамт Сургалтын төрийн санд албан ёсоор хүлээлгэн өгнө.

34. Суралцагч сургалтын төлбөрийн зээлийг сургууль төгссөнөөс хойш 10 жилийн дотор бүрэн төлж барагдуулна. Ингэхдээ эхний 6 жилийн дотор хүүгүй, долоо дахь жилээс эхлэн арилжааны банкны жилийн дундаж хүүгээс 0,5-аар илүү хүүтэйгээр 4 жилгийн дотор зээл, хүүгийн хамт төлнө.

35. Суралцагч сургууль төгсөөд төрийн захиргаа, үйлчилгээний болон дээд боловсрол олгох байгууллагад хөдөлмөрийн гэрээний дагуу эзэмшсэн мэргэжлээрээ 5 жил үр бүтээлтэй ажилласан бол тухайн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн сургалтын төлбөрийн зээлийг чөлөөлж болно. Чөлөөлөх асуудлыг Сургалтын төрийн сангийн Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

36. Суралцагч нас барсан болон хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу 70-аас дээш жувиар алдсан нөхцөлд түүнийг зээл болон хүүгийн төлбөрөөс чөлөөлнө.

37. Засгийн газар хоорондын тэнцүү солилцоогоор гадаадад суралцагч нь гэрээ байгуулах болон сунгуулахдаа тус улсын төрийн өмчийн адилтгах их сургуулийн тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн жишгээр Сургалтын төрийн санд

сургалтын төлбөр төлнө.

38. Засгийн газар хоорондын тэнцүү солилцоогоор суралцагч нь хичээлийн эхний жилийн дүнгээрээ тухайн орны сурлагын үнэлгээний 75 хувиас дээш амжилт үзүүлснийг нотолсон суралцах сургуулийн тодорхойлолтыг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр сургалтын төлбөрөөс чөлөөлж болно.

39. Засгийн газар хоорондын тэнцүү солилцоогоор суралцагч хугацаандаа сургуулиа төгсөж чадаагүй, төгсөөд эх орондоо ирээгүй, захиалагч газартаа 5-аас доошгүй жил ажиллаагүй нөхцөлд сургалтын болон тэтгэлгийн зээлийг авсан өдрөөс эхлэн тооцож банкны өр барагдуулах зээлийн хүүгийн жишгээр суралцагч (итгэмжлэгдсэн төлөөлөгч)-аас төлүүлэх бөгөөд энэ талаар гурвалсан гэрээнд заавал тусгасан байна. Энэхүү төлбөрийг барагдуулах асуудлыг гэрээний дагуу Сургалтын төрийн сан хариуцан гүйцэтгэнэ.

40. Засгийн газрын тэнцүү солилцоогоор гадаадад мэргэжил дээшлүүлэгчид Сургалтын төрийн санд сургалтын төлбөр төлнө. Уг төлбөрийн хэмжээг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

41. Сургалтын төлбөрийн зээл нь их сургууль, коллежид суралцах хугацаанд хүүгүй байна.

Долоо. Хариуцлага

42. Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн гэрээ, тэдгээрийн санхүүжилттэй холбогдон гарсан маргааныг Сургалтын төрийн сангийн Удирдах зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ.

43. Суралцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч түүний өмнөөс холбогдох гэрээнд гарын үсэг зурж байгуулах бөгөөд сунгана. Суралцагч нь сургалтын төлбөр, тэтгэлэг болон замын зардлын зээлийг барагдуулаагүй тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгч тэдгээрийг барагдуулах хариуцлагыг жууль тогтоомжийн дагуу хүлээнэ.

44. Сургалтын төлбөрийн зээл авах хүсэлт гаргасан суралцагчийн талаар тодорхойлолт өгсөн тухайн шатны Засаг дарга тодорхойлолтынхоо үнэн зөвийг хариуцах бөгөөд тухайн суралцагчийг төгсөөд орон нутагтаа ажиллуулах, сургалтын төлбөрийг барагдуулахад хяналт тавина.

45. Суралцах хугацаандаа авсан зээлээ хүүгийн хамт тогтоосон хугацаанд төлөөгүй суралцагчдын төлбөрийг барагдуулах талаар Сургалтын төрийн сан зохих журмын дагуу шүүхэд хандана.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн анхан шатны /8 дугаар анги төгсөөд элссэн/ ангийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээг хавсралтын ёсоор баталж, 2001 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдсүгэй.

2."Ерөнхий боловсролын сургуулийн болон дотуур байрны нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1999 оны 144 дүгээр тогтоолын дагуу мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын хэмжээг тооцож байсугай.

3.Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн болон дотуур байрны дулаан, цахилгаан, ус, тээврийн зардлыг төсвөөс санхүүжүүлж байсугай.

4.Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн дипломын ангийн суралцагчдын тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг хамтран тогтоож байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Гэгээрлийн сайд А.Баттөр нарт даалгасугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Гэгээрлийн сайд

А.БАТТӨР

Засгийн газрын 2000 оны 97 дугаар тогтоолын хавсралт

МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН АНХАН ШАТНЫ АНГИЙН НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

№	Мэргэжил	Нэг суралцагчид ногдох хувьсах зардал (төг)	Үүнээс: бүсээр тооцогдох итгэлцүүр			
			Нийслэлд байрладаг	Нийслэлээс алслагдсан		
				150-500 км	500-1000 км	1000-аас дээш км
			I бүс	II бүс	III бүс	IV бүс
1	Хүнсний үйлдвэрлэл	129900	1,0	1,03	1,06	1,09
2	Хөнгөний үйлдвэрлэл	130100	1,0	1,03	1,06	1,09
3	Үйлдвэрлэл, үйлчилгээ	131100	1,0	1,03	1,06	1,09
4	Барилга, сантехник	130600	1,0	1,03	1,06	1,09
5	Хөдөө аж ахуй	131400	1,0	1,03	1,06	1,09
6	Техник, технологи	131400	1,0	1,03	1,06	1,09

Тайлбар: а/ бүсэд нийслэл болон түүнээс 150 км-ийн зайн дотор орших мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв;

б/II бүсэд нийслэлээс 150-500 км-ийн зайд орших мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв буюу Архангай, Булган, Дархан-уул, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий, Орхон аймаг;

в/III бүсэд нийслэлээс 500-1000 км-ийн зайд орших мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв буюу Баянхонгор, Завхан, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл аймаг;

г/IV бүсэд нийслэлээс 1000 км-ээс цааш зайд орших мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв буюу Баян-өлгий, Говь-алтай, Увс, Ховд аймаг тус тус орно.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэл, аймгийн төвөөс бусад газарт байрлах хорих анги, хэсэгт алба хааж байгаа офицер, ахлагч нарт олгох хоногийн хүнсний хангамжийн хэмжээг хавсралтын ёсоор баталж, үүнтэй холбогдон гарах нэмэгдэл зардлыг жил бүрийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

2. Чанга дэглэмтэй хорих ангид ял эдлэх хоригдлын тоо өссөнтэй уялдуулан Говьсүмбэр, Хөвсгөл аймаг дахь жирийн дэглэмтэй хорих анги, Улаанбаатар хот дахь Урьдчилан цагдан хорих байрны дэргэд байрладаг Барилгын материалын үйлдвэрийн ашиглалтын өмнөх захиргааг 2000 оны Ш улиралд багтаан чанга дэглэмтэй хорих анги болгон өөрчлөн зохион байгуулсугай.

3. Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар, түүний нэгж, байгууллагад алба

халиж байгаа ажилтнуудын ажлын ачааллын нормативыг энэ оны Ш улиралд багтаан тогтоохыг Хууль зүйн сайд Д.Ганболд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонин нарт тус тус даалгасугай.

4. Шинээр байгуулагдсан чанга дэглэмтэй хорих ангиуд, гяндан болон хугацаагүй хорих тусгай салбарын дохиолол, харуул хамгаалалтыг дотоодын цэргийн хамгаалалтад авах арга хэмжээг энэ онд багтаан шийдвэрлэхийг Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ч.Амарболдод даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Хууль зүйн сайд

Д.ГАНБОЛД

Засгийн газрын 2000 оны 98 дугаар тогтоолын хавсралт

ХОРИХ АНГИУДАД АЛБА ХААЖ БАЙГАА ОФИЦЕР, АХЛАГЧ НАРЫН ХОНОГИЙН ХҮНСНИЙ ХАНГАМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Хүнсний бүтээгдэхүүний нэр	Хэмжээ (грамм)
1	Мах	500
2	Гурил	500
3	Цөцгийн тос	40
4	Элсэн чихэр	60

Тайлбар: Дээрх нэр төрлийн бүтээгдэхүүн байхгүй тохиолдолд бусад хүнсний бүтээгдэхүүнээр орлуулан зохих журмын дагуу тогтоосон илчлэгт нь багтаан хэрэглэж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

Орон сууц хувьчлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, Орон сууц

хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



"Бэрх-уул" төрийн өмчит үйлдвэрийн газрын 576 айлын орон сууцны 29 барилгын үнийг нэг бүрчлэн нарийвчлан шалгаж "Бэрх-уул" төрийн өмчит үйлдвэрийн газрын хөрөнгөөс хасч, Орон сууц хувьчлах тухай хуулийн дагуу эзэмшигчдэд нь хувьчлах

ажлыг зохион байгуулахыг Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригтод даалгасугай.

Монгол Улсын

Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Сангийн сайд

Я.ОЧИРСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 6 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Зөвлөхийг сонгоход баримтлах тусгай журам"-ыг 2 дугаар хавсралтаар, "Худалдан авах ажиллагаанд оролцогч төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах худалдан авах ажиллагааны журам, заавар, тендерийн жишиг бичиг баримт, үлгэрчилсэн гэрээ болон шаардлагатай бусад баримт бичгийг боловсруулж мөрдүүлэх, холбогдох хууль тогтоомж, журмуудыг сурталчлах, хэвлүүлэх, төрийн албан хаагчдын дунд өргөн хүрээтэй сургалт зохион байгуулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхийг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль, түүнийг дагалдаж гарах дүрэм, журам, заавар, жишиг бичиг баримт болон худалдан авах ажиллагаанд оролцогч төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг нэг мөр дагаж мөрдүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг сайд, бүх шатны Засаг дарга, 50-иас дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газрын удирдлагад үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төсөл шалгаруулах журам батлах тухай" Засгийн газрын 1995 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай. Үүнтэй холбогдуулан яам, агентлагуудаас батлан гаргаж мөрдүүлж буй тендер шалгаруулалттай холбоотой журам, дүрмүүдийг хүчингүй болсонд тооцохыг сайд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын

Ерөнхий сайд

Р.АМАРЖАРГАЛ

Сангийн сайд

Я.ОЧИРСҮХ



Засгийн газрын 2000 оны 101 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

БАРАА, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОХОД БАРИМТЛАХ ТУСГАЙ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн (цаашид "хууль" гэх) дагуу төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгох ажиллагаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд Сангийн яамны худалдан авах

ажиллагааг хариуцсан алба, холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага тус тусын чиглэлээр хяналт тавина.

3. Хуулийн дагуу байгуулагдах тендерийн хороо нь орон тооны бус байх бөгөөд түүний шийдвэрийг тухайн тендерийн хороог байгуулсан байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр гаргаж, тамга, тэмдгээр нь баталгаажуулна.

Хоёр.Худалдан авах ажиллагааны төлөвлөлт

4. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт нь захиалагчийн¹ хэрэгцээг цаг хугацаанд нь зүй зохистой санхүүжилтээр хангах, худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтнуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулахад чиглэгдэнэ. Төлөвлөлтийн явцад хэрэглэх жишиг маягтуудыг энэ журмын 1-6 дугаар хавсралтад тусгав.

5. Захиалагч нь төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр дараа онд худалдан авах бараа, ажлын төслийг боловсруулж дараа оны төлөвлөгөөний төслийн хамт улсын төвлөрсөн төсвийн хувьд Сангийн яаманд, орон нутгийн төсвийн хувьд тухайн шатны Засаг даргад тус тус ирүүлнэ.

6. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд түүний удирдлага, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага) дараа онд худалдан авах бараа, ажлын төслийг зохиож журмын дагуу батална.

7. Тухайн жилд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажлын төслийг баталж, холбогдох шийдвэр гарсны дараа захиалагч нь бараа, ажлын гүйцэтгэгч сонгох ажиллагааны төлөвлөлтийг бэлтгэнэ.

8. Захиалагч тухайн жилд худалдан авах бараа, ажлын төлөвлөлтийг удирдах дээд шатны байгууллагаар батлуулна.

9. Төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагчийн тухайн зардлын нэр төрлөөр бараа, ажил худалдан авах жилийн хэрэгцээ нь 50,0 сая төгрөгөөс дээш гарах тохиолдолд жилийн нийт хэрэгцээгээр хууль болон энэхүү журмын дагуу худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулна. Ингэхдээ тухайн бараа, ажил хүлээн авах сар, улирлын хуваарь, төлбөр тооцооны зарчмыг тендерийн бичиг баримт болон гэрээнд тодорхой заана.

10.Төсвийн ерөнхийлөн захирагч болон төвлөрүүлэн захирагчаас шаардлагатай тохиолдолд тодорхой нэр

¹ Энэхүү журам болон худалдан авах ажиллагаатай холбоотой бусад бүх баримт бичигт захиалагч гэдгийг худалдан авах ажиллагааг Засгийн газрын буюу ашиглагч байгууллагын нэрийн өмнөөс хэрэгжүүлж буй аливаа байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан /худалдан авах байгууллага, ерөнхий захиалагч, жинхэнэ захиалагч, захиалагчид туслах зорилгоор байгуулагдсан тендерийн хороо, үнэлгээний хэсэг/ гэсэн өргөн утгаар ойлгоно.



төрлийн бараа, ажлын тендер шалгаруулалтыг нэгдсэн журмаар зохион байгуулсны үндсэн дээр гэрээ байгуулан бараа, ажил нийлүүлэх арга хэмжээ авч болно. Энэ тохиолдолд ерөнхийлөн захирагчийн хувьд Засгийн газар, Ерөнхий сайд, холбогдох аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын тогтоол шийдвэр, захирамж, төвлөрүүлэн захирагчийн хувьд Сангийн яамны шийдвэрийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулах тендер шалгаруулалтад хамрагдах бараа, ажлын нэр төрөл, байгууллагын жагсаалт, үйлчлэх хугацааг тодорхойлно.

11. Бараа, ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөлт нь дараахь үе шатуудтай байна:

а) худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах;

б) худалдан авах бараа, ажлын жагсаалтыг зарлан мэдээлэх;

в) тендерийн хороо болон үнэлгээний хэсгийг байгуулах;

г) гүйцэтгэгч сонгох ажиллагааны журмыг сонгох;

д) хязгаарлагдмал тендер шалгаруулалт болон шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэх бол үндэслэлийг гаргах;

е) тендерийн бичиг баримтыг бэлтгэх;

ж) тендерийн урилга гаргах, зарлан мэдээлэх;

з) тендерийг нээх;

и) тендерийг үнэлэх;

к) гэрээ байгуулах эрх олгох;

л) гэрээний хэлэлцээг эхлэх, дуусгах, гэрээ байгуулах;

м) гэрээний хэрэгжилт.

12. Захиалагч нь тухайн жилд худалдан авах бараа, ажлын жагсаалтыг өдөр тутмын болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

Гурав. Гүйцэтгэгчийг сонгох ажиллагааны зохион байгуулалт

13. Тухайн жилд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажлын төслийг баталсан холбогдох шийдвэр гарсны дараа хуулийн 7 дугаар бүлэгт заасны дагуу тендерийн хороо болон үнэлгээний хэсгийг байгуулна.

14. Тендерийн хороо нь дарга болон 2-оос доошгүй гишүүнээс бүрдэнэ. Тендерийн хорооны хэлбэр болон бүрэлдэхүүнийг энэ журмын 7 дугаар хавсралтад тусгав.

15. Тендерийн хорооны шийдвэрийн дагуу хорооны даргаас бусад гишүүнийг үнэлгээний хэсгийн гишүүнээр томилж болох боловч тэдгээр нь үнэлгээний хэсгийн 2/3-оос илүү байж болохгүй. Тендерийн хороо, үнэлгээний хэсгийн гишүүн нь тухайн худалдан авах ажиллагаатай ямар нэгэн сонирхлын зөрчилгүй этгээд байвал зохино.

16. Үнэлгээний хэсэг нь бараа, ажлын гүйцэтгэгч сонгох ажиллагаанд хэрэглэх журмыг сонгох, тендерийн бичиг баримтыг бэлтгэх, тендерийн урилгыг

зарлан мэдээлэх болон тендерийг үнэлэх ажлуудыг гүйцэтгэж, гэрээ байгуулах эрх олгох тухай дүгнэлт гаргаж тендерийн хороонд танилцуулна.

17. Үнэлгээний хэсгийн санал, дүгнэлтийг тендерийн хорооны хуралдаанаар авч хэлэлцэн гишүүдийн олонхийн саналаар ил санал хурааж, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж гаргана.

18. Захиалагч нь тендерийн хорооны зөвлөмжийг үндэслэн гэрээ байгуулах эрхийг уг зөвлөмжийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шалгарсан тендерт оролцогчид олгоно.

19. Тендерийн хороо аливаа асуудлыг хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ. Тендерийн хороо энэхүү журмын 11-д заасан холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор болон шаардлагатай тухай бүр хуралдана.

20. Тендерийн хорооны хуралдааныг хорооны гишүүдийн 80-аас дээш хувь нь ирсэн тохиолдолд хүчин төгөлдөрт тооцно. Тендерийн хорооны бүх гишүүд



саналын тэгш эрх эдэлнэ. Тендерийн жоррооны гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хорооны даргын саналаар шийдвэрлэнэ. Цөөнх болсон гишүүн бүрийн саналыг үндэслэлийн хамт тендерийн хорооны шийдвэрт хавсаргана.

21. Тендерийн хорооны хурал дааны дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлө; бөгөөд хуралдаанд байлцсан бүх гишүүд түүнд гарын үсэг зурж баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд хорооны хуралдааны явцын талаар бичлэг хийх болно.

Дөрөв. Бараа, ажлын гүйцэтгэчийг сонгох ажиллагааны журмууд

Нээлттэй тендер шалгаруулалт

22. Бараа, ажлын гүйцэтгэчийг сонгохдоо хуулийн 25.1, 26.1, 27.1-д заасан онцгой журам хэрэглэх нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

23. Нээлттэй тендер шалгаруулалт нь шаардлагатай бараа, ажлыг хамгийн боломжит бодит үнээр худалдан авах, бүж тендер оролцогчдод өрсөлдөх тэгш боломж олгох, гүйцэтгэчийг сонгох ажиллагааг бүх талуудад урьдчилан тодорхойлж мэдэгдсэн шалгуурын дагуу нээлттэй, ил тод байдлаар явуулах, авилгал гарах боломжийг бууруулахад чиглэгдэнэ.

24. Нээлттэй тендер шалгаруулалтыг нэг буюу хоёр үе шаттай явуулж болно. Хуулийн 12.1-д зааснаас бусад тохиолдолд нэг үе шаттай аргыг хэрэглэнэ.

25. Хоёр үе шаттай нээлттэй тендер шалгаруулалтыг хуулийн 12.1-д заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд тухайн тендерийн хорооны даргын шийдвэрийг үндэслэн хэрэглэнэ.

Хязгаарлагдмал тендер шалгаруулалт, шууд гэрээ байгуулах

26. Хуулийн 25.1, 26.1-д заасан онцгой журам хэрэглэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд хязгаарлагдмал тендер шалгаруулалтыг хэрэглэнэ.

27. Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журам хэрэглэх үед хуулийн 37 дугаар зүйлд заасан бүртгэлд бүртгэгдсэн тендер оролцогчдоос тодорхой тооны оролцогчдыг сонгоно. Хэрэв тухайн бараа, ажлын гүйцэтгэчийн бүртгэл байхгүй буюу бүртгэлд тохирох

ангилал байхгүй бол чадвартай гүйцэтгэгч, нийлүүлэгчдээс сонгож болно.

28. Хязгаарлагдмал тендер шалгаруулалт болон шууд гэрээ байгуулах үед урилга аваагүй боловч тухайн бараа, ажлыг гүйцэтгэх чадвартай бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгч оролцох үүсэлтээ бичгээр гаргасан тохиолдолд түүнийг тухайн тендер шалгаруулалтад оролцуулахаас татгалзахыг хориглоно.

29. Хуулийн 27.1-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч шууд гэрээ байгуулах аргыг хэрэглэж болно.

Урьдчилсан сонголт

30. Томоохон барилга байгууламжийн ажил, түлхүүр гардуулах, өндөр үнэтэй болон техникийн нарийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээнд зөвхөн техникийн болон санхүүгийн чадвар бүхий компаниудыг тендер шалгаруулалтад оролцуулах нөхцөл, боломжийг хангах зорилгоор урьдчилсан сонголтыг явуулж болно. Урьдчилсан сонголтыг явуулахдаа эдгээр компаниудын зохих туршлага, өмнөх, ажлын гүйцэтгэл, боловсон хүчин, тоног төхөөрөмж, байгууламж болон үйлдвэрлэлийн чадвар, санхүүгийн байдал зэргийг авч үзнэ.

31. Урьдчилсан сонголтыг явуулахдаа Сангийн яамнаас гаргасан урьдчилсан сонголтын жишиг бичиг баримтыг мөрдөнө.

32. Урьдчилсан сонголт явуулсан үед тендерийн урилга болон тендерийн бичиг баримтыг зөвхөн урьдчилсан сонголтод тэнцсэн тендер оролцогчдод илгээж, тендер шалгаруулалтад оролцуулна.



Тав.Тендерийн бичиг баримт

33. Захиалагч нь шаардлагад нийцсэн тендер бэлтгэх боломжийг тендерт оролцогчдод олгох зорилгоор тендерийн бичиг баримтыг бэлтгэх бөгөөд тендерийн бичиг баримт нь дараахь зүйлээс бүрдэнэ:

- а) тендерийн урилга;
- б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа;
- в) тендерийн маягт;
- г) гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл;
- д) техникийн тодорхойлолт;
- е) ажлын тоо хэмжээ буюу үнийн хуваарь;
- ж) зураг (боломжгүй бол зурагтай танилцах хаягийг заах);
- з)тендерийн баталгааны болон гүйцэтгэлийн баталгааны маягт (шаардлагатай бол);
- и) бусад шаардлагатай материал.

34. Захиалагч нь Сангийн яамнаас гаргасан холбогдох тендерийн жишиг бичиг баримтыг мөрдөнө. Жишиг бичиг баримтын жагсаалтыг энэ журмын 8, 9 дүгээр хавсралтад тусгав. Тухайн бараа, ажлын онцлогоос шалтгаалан тендерийн бичиг баримтад өөрчлөлт оруулах шаардлагатай бол зөвхөн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа болон гэрээний тусгай нөхцөлд оруулна.

35.Бараа, ажил болон тэдгээрийг бэлтгэн нийлүүлэх, суурилуулах хугацаа, байршил, баталгаат засвар, засвар үйлчилгээ болон шаардлагатай бусад нөхцөлийг тендерийн бичиг баримтад тодорхой тусгана.

36. Захиалагч худалдан авах бараа, ажлын шинж чанар, үйл ажиллагаа, аюулгүй байдал, түүнчлэн хэмжээ, таних тэмдэг, нэр томъёо, баглаа боодол, барааны нэр, шошго, эсхүл тэдгээрийн үйлдвэрлэлийн арга технологи, захиалагчаас мөрдөх стандарт болон журамд хамаарах шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгахдаа нэг буюу хэд хэдэн тендерт оролцогчдод бусдаас давуу байдал үүсгэх, ялгаварлах байдлаар бэлтгэх,

тогтоох, хэрэглэж болохгүй.

37.Тендерийн бичиг баримтад тендерийг үнэлэх арга, нөхцөл болзол болон тендерүүдийг харьцуулахад харгалзах шалгуур үзүүлэлтийг тусгана

38.Үндсэн тендерээс гадна тухайн бараа, ажлыг гүйцэтгэх өөр хувилбарыг (хувилбарт тендер) ирүүлэхийг зөвшөөрөх бол энэ тухай тендерийн бичиг баримтад тусгайлан заана.

39.Тендерийн бичиг баримттай холбоотой нэмэлт мэдээлэл, тайлбар, залруулга, эсхүл. нэмэлт, өөрчлөлт гарвал энэ тухай тендерийн бичиг баримт авсан бүх тендерт оролцогчдод бичгээр мэдэгдэнэ.

Тендерийн баталгаа

40. Захиалагч тендерийн хүчинтэй байдлыг тендерийн урилгад заасан хугацаанд баталгаажуулах зорилгоор тендерийн баталгаа ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно. Тендерийн баталгааны гол зорилго нь шаардлагад үл нийцсэн, эсхүл хуурамч тендерээс захиалагчийг хамгаалахад оршино. Тендерийн хамт тендерийн баталгаа ирүүлэхийг шаардсан тохиолдолд түүнийг ирүүлээгүй оролцогчийн тендерээс татгалзана.

41. Худалдан авах ажлын өртөг 50 сая төгрөгөөс, барааны өртөг 30 сая төгрөгөөс дээш бол тендерийн баталгаа ирүүлэхийг заавал шаардана. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28-30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендер хүчинтэй байх хугацаа

42. Тендер нь тендерийн бичиг баримтад заасан хугацаанд хүчинтэй байна. Тендер хүчинтэй байх хугацааг тендерийг нээсэн өдрөөс эхлэн гэрээ байгуулах үйл ажиллагаа дуусахад хүрэлцэхүйц байхаар тогтооно. Ийнхүү тогтоохдоо Сангийн яамнаас гаргасан тендерийн жишиг бичиг баримтуудад заасан хугацааг харгалзан үзнэ.



43. Захиалагч тендер хүчинтэй байх хугацааг сунгалгүйгээр тендерийн үнэлгээг явуулахад шаардагдах бүх арга хэмжээг авна. Онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд тендерийн хороо тендер хүчинтэй байх хугацааг сунгах асуудлыг шийдвэрлэнэ. Хугацаа сунгасан тохиолдолд тендерийн хороо бүх оролцогчдод хандаж өөр өөрсдийн тендер хүчинтэй байх хугацааг сунгах талаар хүсэлт гаргана. Өөрийн тендер хүчинтэй байх хугацааг сунгахыг зөвшөөрсөн тендер оролцогчоос тендерийнх нь агуулгыг өөрчлөхийг санал болгох, эсхүл өөрчлөлт оруулахыг зөвшөөрөхийг хориглоно. Өөрийн тендер хүчинтэй байх хугацааг сунгаагүйгээс тендер шалгаруулалтад цаашид оролцох боломжгүй болсон оролцогчийн тендерийн баталгааг хүчингүй болгоно.

Гэрээний төрөл, хэмжээ, нөхцөл

44. Бараа, ажлын онцлогоос хамааран гэрээг нэгж үнэ, нийт үнэ, эсхүл тэдгээрийн хосолсон хэлбэрээр байгуулж болно. Гэрээг ямар хэлбэрээр байгуулахыг тендерийн бичиг баримтад заана.

45. Худалдан авах ажиллагааны цар хүрээ, ажлын технологийн онцлог болон байршлаас хамааран бараа, ажлыг багцалж гэрээ байгуулж болно.

46. Нарийн технологи, нэгдмэл үйлдвэрлэл шаардлагатай тохиолдолд захиалагч нь түлхүүр гардуулах гэрээг хэрэглэж болно.

47. Гэрээний ерөнхий нөхцөлд захиалагч, бэлтгэн нийлүүлэгч болон гүйцэтгэгчийн эрх, үүрэг, бараа, ажлын тодорхойлолт, захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх инженер, архитекторын эрх, төлбөрийн хуваарь, гүйцэтгэлийн баталгаа, баталгаат засварын барьцаа, үнийн тохируулалт, даатгал, алданги зэрэг зүйлсийг тусгана. Бараа, ажлын онцлогоос хамааран шаардлагатай бусад

нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд тусгаж болно.

48. Ажил гүйцэтгэх үед бараа нийлүүлэлтийн үнэ нь ажлын үнээс их байвал тухайн гэрээг барааны гэрээ гэж үзнэ. Барааны үнэд тухайн ажил гүйцэтгэхэд шаардагдах барилгын материалын үнэ орохгүй.

Тендерийн үнэ

49. Гадаадаас санал болгох барааны үнэд CIF² (СИФ), CIP (СИП)-ийн аль нэгийг, дотоодоос нийлүүлэх бололцоотой, эсхүл дотоодод үйлдвэрлэж, угсарсан, эсхүл урьд нь импортоор оруулж ирсэн барааны санал болгох үнэд EXW³ (ИКСБ) нөхцөлийг үндэслэнэ. Хэрэв барааг хуурай замаар тээвэрлэх, эсхүл угсрах, ашиглалтад оруулах болон эдгээртэй адилтгах бусад үйлчилгээг гэрээнд хэрэгжүүлэх шаардлагатай бол үнийг тусад нь санал болгоно.

50. Захиалагч импортлох барааны тээвэрлэлт болон даатгалыг тусад нь шийдэх сонирхолтой бол санал болгох үнийг CIF, CIP-ийн аль нэгээс гадна FOB (ФОБ), CFR (СФР)-ийн аль нэг үнэд үндэслэнэ. Тендер шалгаруулалтын үнэлгээг зөвхөн CIF, CIP үнэд үндэслэх боловч захиалагч гэрээг FOB, CFR нөхцөлөөр байгуулж, өөрөө тээвэрлэлт болон даатгалыг, эсхүл аль нэгийг нь хариуцаж болно.

51. Түлхүүр гардуулах гэрээнд тоног төхөөрөмж, далайн болон хуурай замын тээвэр, даатгал, суурилуулалт, ашиглалтад өгөх, гэрээнд шаардсан бол зураг төсөл, засвар үйлчилгээ, ашиглалт зэрэг бүх үйлчилгээний үнийг тусгана. Тендерийн бичиг баримтад өөрөөр заагаагүй бол энэ үнэд татвар, шимтгэл болон бусад төрлийн хураамжийг оруулж тооцно.

52. Барилга байгууламжийн ажилд нэгж үнэ, эсхүл нийт үнийг ирүүлэхийг тендер оролцогчоос шаардах бөгөөд энэ үнэд татвар, шимтгэл болон бусад төрлийн хураамжийг оруулсан байна.

² Энд дурдсан нөхцөлүүдийг ИНКОТЕРМС (INCOTERMS)-д дурдсанаар ойлгоно. CIF гэдэг нь далайн тээвэрлэлтийн үед (нэр заасан газар хүртэлх) тухайн барааны өртөг, тээвэр болон даатгалын зардлыг хамарна. CIP гэдэг нь тээврийн хэрэгслийг хосолсон үед (нэр заасан газар хүртэлх) тээвэр болон даатгалыг хамарна. FOB гэдэг нь хөлөг онгоцонд ачих хүртэлх зардлыг хамарна. CFR гэдэг нь тухайн барааны өртөг болон тээврийн зардлыг хамарна.

³ EXW гэдэг нь ажил, үйлдвэр, эсхүл лангууны үнийг хэлнэ. EXW үнэ нь тухайн барааг үйлдвэрлэх, угсрахад хэрэглэсэн түүхий эд, эд анги, эсхүл барааг импортлохын өмнө төлөх бүх хураамж, татварыг багтаана.

Тендерийн тооцоонд хэрэглэх валют болон тендерийг харьцуулах валют

53. Тендерийн үнийг төгрөгөөр илэрхийлэхийг тендерийн бичиг баримтад заана. Төгрөгөөс бусад валютыг төлбөр тооцоонд зайлшгүй ашиглах тохиолдолд тендер зарласан өдрийн Монгол банкны албан ханшаар хөрвүүлэн тендерийн үнэлгээнд ашиглана. Тендерийн үнийг илэрхийлэх валютыг тендерийн бичиг баримтад тодорхой заана.

Үнийг тохируулах нөхцөл

54. Гэрээний үнийн гол бүрэлдэхүүн болох ажиллах хүч, тоног төхөөрөмж, материалын үнэ гүйцэтгэгчээс үл шалтгаалан өөрчлөгдсөн тохиолдолд гэрээний үнийг хэрхэн тохируулах тухай нөхцөлийг тендерийн бичиг баримтад тусгаж болно. Урт буюу 12 сараас дээш хугацааны гэрээнд үнийг хэрхэн тохируулах талаар заавал тусгана. Богино хугацааны энгийн гэрээнд үнийн тохируулга хийх шаардлагагүй. Суурь үнэ огцом өөрчлөгдсөн тохиолдолд захиалагч, гүйцэтгэчийг алдагдалд орохоос хамгаалах зорилгоор үнийг өсгөх болон бууруулахаар тусгаж болно.

55. Гэрээний үнийн зөвхөн гол бүрэлдэхүүн хэсгийн үнийн өөрчлөлтийг тохируулна. Үнийг тохируулах аргачлалыг тендерийн бичиг баримтад тусгана.

Урьдчилгаа төлбөр

56. Бараа, ажлыг гүйцэтгэх зориулалтаар хөрөнгө төвлөрүүлэх, материал хүргэх зардалд зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлж болно. Урьдчилгааны дүн, түүнийг хэзээ, хэрхэн төлөх, ямар төрлийн баталгаа шаардагдах, хэрхэн суутгаж тооцох зэргийг Сангийн яам болон хөрөнгө зарцуулах эрх бүхий холбогдох байгууллага, албан тушаалтантай зөвшилцсөний үндсэн дээр тендерийн бичиг баримтад тусгана. Урьдчилгаа төлбөр хийж болох бараа, ажлын нэр төрлийг тендерийн бичиг баримтад тусгана. Тендерийн бичиг баримтад тусгагдаагүй тохиолдолд урьдчилгаа төлөхгүй.

Гүйцэтгэлийн баталгаа, баталгаат засварын барьцаа

57. Захиалагч ажил гүйцэтгэх гэрээнд шалгарсан тендэрт оролцогчийн гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор түүнээс гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг шаардаж болно. Энэ тохиолдолд гүйцэтгэлийн баталгааны маяг, дүнг тендерийн бичиг баримтад тодорхой заана. Гүйцэтгэлийн баталгаа нь захиалагчийн эрх ашгийг хамгаалахад хүрэлцэхүйц хэмжээтэй байх бөгөөд тухайн ажлын онцлог, цар хүрээнээс хамаарч гэрээний үнийн 5-10 хувьтай тэнцүү байна. Гүйцэтгэлийн баталгаа нь захиалагчаас тухайн ажлыг хүлээн автал хүчинтэй байна.

58. Гүйцэтгэлийн баталгаат засвар хийх үүргийн биелэлтийг баталгаажуулах

зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг баталгаат засварын хугацаа дуустал барьцаа болгон авч үлдэх нөхцөлийг захиалагч тендерийн бичиг баримтад тусгаж болно. Гүйцэтгэгч нь банкны төлбөрийн батлан даалт гаргаж түүнтэй тэнцүү дүнтэй хөрөнгийг баталгаат засварын барьцаа мөнгөнөөс урьдчилан авах эрхтэй байж болно.

59. Бараа бэлтгэн нийлүүлэх гэрээнд гүйцэтгэлийн баталгаа байх эсэх нь тухайн барааны зах зээлийн онцлог, худалдааны практикаас хамаарна. Бэлтгэн нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэгчээс гэрээний гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор банкны төлбөрийн батлан даалт ирүүлэхийг захиалагч шаардаж болно. Энэ батлан даалтын тодорхой дүнг болон гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг бэлтгэн нийлүүлэгчийн баталгаат засварын үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор барьцаа болгон баталгаат засварын хугацаа дуустал захиалагчаас төлөхгүй гэсэн нөхцөлийг гэрээнд тусгаж болно. Гүйцэтгэлийн баталгаа болон баталгаат засварын барьцаа нь гэрээний үнийн 5-10 хувьтай тэнцүү байна.

Даатгал, тээвэрлэлт

60. Тендерийн бичиг баримтад гүйцэтгэгч, бэлтгэн нийлүүлэгчийн хийлгэх даатгалын төрөл, дүн, даатгах барааны нэр төрөл, хамрах эрсдэл болон хугацааг тусгана. CIF эсхүл CIP нөхцөлийг үндэслэсэн бараа нийлүүлэх гэрээнд бэлтгэн нийлүүлэгч нь ачаа, тээвэрлэлтийн даатгалыг гэрээний дагуу хийнэ. FOB буюу CFR нөхцөлийг үндэслэсэн бараа нийлүүлэх гэрээнд ачааны болон тээврийн даатгалыг захиалагч хариуцна.

Алданги

61. Бараа, ажлыг хугацаанд нь бэлтгэн нийлүүлээгүйн улмаас бэлтгэн нийлүүлэгч болон гүйцэтгэгчээс захиалагчид төлөх алдангийн хэмжээг гэрээ болон тендерийн бичиг баримтад тусгана.

Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал

62. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэний улмаас гэрээний аль нэг тал гэрээний үүргээ биелүүлээгүй бол хариуцлага тооцохгүй байх нөхцөлийг гэрээ болон тендерийн бичиг баримтад тусгаж болно.

Маргааныг шийдвэрлэх

63. Гэрээний нөхцөл болон үүргийн биелэлтэй холбогдон гарах маргааныг шийдвэрлэх арга замыг гэрээний нөхцөлд тодорхой тусгана. Бараа, ажил худалдан авах олон улсын гэрээтэй холбогдуулан маргаан гарсан тохиолдолд ямар улсын хуулийг хэрэглэх, аль улсын шүүх, эсхүл арбитраар шийдвэрлүүлэхийг тендерийн бичиг баримтад заавал тусгана.

Зургаа. Тендерийг зарлан мэдээлэх, нээх, хянан үзэх, үнэлэх

Зарлан мэдээлэл

64. Нээлттэй тендер шалгаруулалтын журам хэрэглэх үед тендерийн бичиг баримтыг бэлэн болмоц хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу тендер шалгаруулалт явуулах тухай зарлал, мэдээллийг едөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр хугацаа алдалгүй нийтэд зарлана. Олон улсын тендер шалгаруулалтын үед дээрх урилгыг Сангийн яамны интернетиин вэб хуудсан дээр сурталчлах бөгөөд бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгч нь оролдох магадлал бүхий улсын Монгол Улс дахь Элчин сайдын яам, худалдааны төлөөлөгчид хургуулна.

65. Тендерийн урилга буюу зарлал мэдээлэлд дараах зүйлийг заавал тусгана:

а) захиалагч, эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолт;

б) худалдан авах бараа, ажлын товч агуулга;

в) тендерийн бичиг баримт, бусад мэдээлэл авах болон тендер ирүүлэх хаяг;

г) тендерийн бичиг баримтын үнэ (худалдах бол);

д) гүйцэтгэгч сонгох ажиллагаанд тавих шаардлага;

е) тендер хүлээн авах эцсийн хугацаа;

ж) тендер нээх хугацаа;

з) бусад шаардлагатай зааварчилгаа.

Тендерийн бичиг баримтыг тараах

66. Тендерийн бичиг баримтыг түүнийг бэлтгэхэд зарцуулсан өртгөөр үнэлж, тендер шалгаруулалтад оролцохыг хүсэгчдэд уг үнээр саадгүй олгоно.

Тендер бэлтгэх хугацаа

67. Тендер бэлтгэх хугацаа нь худалдан авах бараа, ажлын цар хүрээ, онцлогоос хамаарна. Тендер бэлтгэх хугацаа нээлттэй тендер шалгаруулалтад 30, хязгаарлагдмал тендер шалгаруулалтад 15, шууд гэрээ байгуулахад 10 хоногос доошгүй байна. Томоохон барилга байгууламжийн ажил, түлхүүр гардуулах гэрээ болон зураг төсөл боловсруулах-барьж байгуулах гэрээний үед тендер бэлтгэх хугацаа нь дээр дурдсан хугацаанаас илүү байж болно.

Тендер ирүүлэх

68. Тендерийг тендерийн бичиг баримтад төвлөссон хугацаанд, заасан хаягаар, тогтоосон хэлбэрээр тендерийн хороонд ирүүлнэ.

Тендерийг нээх

69. Тендерийн хорооны гишүүд хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу тендерийн урилгад заасан хугацаанд тендерийн нээлтийг нийтийн өмнө зохион байгуулна. Тендерийг хүлээж авах эцсийн хугацаа дууссанаас хойш 2 цагийн дотор тендерийг нээнэ. Тендерийг нээхэд Сангийн яамнаас гаргасан бараа, ажлын тендерийн үнэлгээний зааврыг ашиглана.

70. Тендерийг нээхэд тендерийн хорооны гишүүд нь тендер оролцогч, түүний төлөөлөгчдөөс тодорхой зайтай байхаар зохион байгуулна.

71. Захиалагч тендерийг нээсний дараа

тендерийн агуулга, ялангуяа үнийн талаар тендер оролцогчтой санал солилцохыг хориглоно. Тендерийн агуулга, үнийг өөрчлөхөөс бусад чиглээр тайлбар, тодруулга ирүүлэхийг захиалагч тендер оролцогчоос шаардаж болно. Эдгээр тайлбар тодруулгыг авахад зөвхөн бичгээр харилцана.

Нууцлал

72. Тендерийг нийтийн өмнө нээсний дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд тендер шалгаруулалттай холбогдсон мэдээллийг захиалагчийн зүгээс зардуулахыг хориглоно.

Тендерийг хянан үзэх, үнэлэх

73. Тендерийг тендерийн бичиг баримтад заасан шаардлагад нийцэж байгаа эсэх, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг байгаа эсэх, ерөнхий эмх гэгц, банкны төлбөрийн батлан даалт, тооцооны алдаа байгаа эсэхийг эхлээд хянаж үзнэ. Тендерийн бичиг баримтад заасан шаардлагад нийцээгүй тендерээс татгалзана.

74. Урьдчилсан сонголт хийгдээгүй бол тендер оролцогчийн туршлага, санхүүгийн болон техникийн байдал, боловсон хүчин, борлуулалтын талаар мэдээлэл ирүүлэхийг тендерийн бичиг баримтад шаардана. Эдгээр шаардлага хангаагүй тендер оролцогчийн ирүүлсэн тендерийг үнэлгээнд оруулахгүй.

75. Хуулийн 21 дүгээр зүйл болон Сангийн яамнаас гаргасан бараа, ажлын тендерийн үнэлгээний жишиг бичиг баримтын дагуу тендерийг үнэлж харьцуулна.

76. Тендерийн бичиг баримтад заасан нөхцөл, үнэлгээний аргын дагуу тендерийг үнэлнэ. Үнэлгээ хийхэд тендерүүдийн зөвхөн үндсэн үнийг харьцуулна. Хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг тодорхойлохдоо үнээс гадна тоног төхөөрөмжийн үр өгөөж, ашиглалтын зардал, ажлыг дуусгах буюу бараа нийлүүлэх хугацаа, борлуулалтын дараах үйлчилгээ, салбэр хэрэгсэл зэрэг холбогдох шалгуур үзүүлэлтийг тендерийн бичиг баримтын дагуу авч үзнэ. Эдгээр шалгуур үзүүлэлтийг боломжтой бол мөнгөн дүнгээр илэрхийлж тендерийн бичиг баримтын үнэлгээний хэсэгт заана. Тендерүүдийг үнийн тохируулгын нөхцөлийг үл харгалзан зөвхөн үндсэн үнийг үндэслэн харьцуулах бөгөөд бараа нийлүүлэх тендерүүдийн хувьд гаалийн болон импортын бусад татварын дүнг харгалзан үзнэ.

Тендерээс татгалзах

77. Хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу бүх тендерээс татгалзаж болно.

78. Захиалагч ирсэн бүх тендерээс татгалзаж болох тухай нөхцөлийг тендерийн бичиг баримтад заана.

Дахин тендер шалгаруулалт явуулах

79. Бүх тендерээс татгалзсан тохиолдолд хуулийн 23.4-т заасан үйл ажиллагааны аль нэгийг авч хэрэгжүүлнэ.

80. Өрсөлдөөн гараагүй, эсхүл техникийн тодорхойлолтыг бүх тендер оролцогч биелүүлээгүй тохиолдолд тендерээс бүхэлд нь татгалзах бөгөөд татгалзах болсон шалтгааныг хянан үзэж техникийн тодорхойлолт, тендерийн

бичиг баримтад шаардлагатай засварыг хийсний дараа дахин тендер шалгаруулалт явуулна.

81.Бүх тендерийн үнэ батлагдсан төсөвт өртгөөс давсан тохиолдолд захиалагч тендерийн хороотой зөвшилцсэний үндсэн дээр дахин тендер шалгаруулалт явуулахгүйгээр хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой төсөвт өртөгт багтсан дүнгээр гэрээ байгуулах зорилгоор бараа, ажлын цар хүрээг багасгах, гэрээний үүргийн гүйцэтгэлийн эрсдэл, хармуцлагыг шилжүүлэн хуваарилах талаар

хэлэлцээ хийж болно. Бараа, ажлын цар хүрээг өөрчлөх нь тухайн худалдан авах ажиллагааны эцсийн зорилго, үр дүнд сөргөөр нөлөөлөх ёсгүй. Бараа, ажлын цар хүрээг 5%-иас дээш бууруулах, гэрээний бичиг баримтыг өөрчлөх нь дахин тендер шалгаруулалт явуулах үндэслэл болно.

82.Бүх тендерээс татгалзсан тохиолдолд зөвхөн бага үнэ олж авах зорилгоор өмнөх тендерийн бичиг баримтыг ашиглаж дахин тендер шалгаруулалт явуулж болохгүй.

Долоо.Гэрээ байгуулах эрх олгох ба гэрээ байгуулах

83.Гэрээ байгуулах эрхийг тендерийн хорооны зөвлөмжийг үндэслэн шалгарсан тендерт оролцогчид захиалагч олгоно. Гэрээ байгуулах эрх олгох нөхцөл болгож техникийн тодорхойлолтод заагаагүй ажил гүйцэтгүүлэх, бараа нийлүүлэх, эсхүл тендерээ өөрчлөхийг шалгарсан тендерт оролцогчоос шаардаж болохгүй.

84.Журамд онцгойлон зааснаас бусад тохиолдолд шалгарсан тендерт оролцогчтой гэрээ байгуулахдаа түүний тендерийн үнээс доогуур үнээр гэрээ байгуулахыг шаардаж болохгүй. Гэхдээ хэлэлцээний дүнд арижааны нөхцөл, техникийн тодорхойлолтыг харилцан тохиролцож өөрчилснөөр гүйцэтгэгчийн зардал

буурсан тохиолдолд гэрээний үнэ нь тендерийн үнээс доогуур болж болно.

85.Захиалагч, эсхүл түүний томилсон төлөөлөгч гэрээ хэлэлцээг зохион байгуулж явуулна. Гэрээ хэлэлцээнд тендерийн хорооны болон үнэлгээний хэсгийн гишүүдээс оролцуулна.

86.Захиалагч болон шалгарсан тендерт оролцогч нь тендерийн хүчинтэй хугацаанд багтаж гэрээ байгуулна. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажлын гэрээний хувьд Сангийн яамны Төсвийн бодлогын газар, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажлын гэрээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газрын төлөвлөлт, санхүү, эдийн засгийн хэлтэсээс зөвшөөрөл авснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

Найм.Давуу эрх

87.Дотоодын бараа болон гүйцэтгэгчид давуу эрх олгох бол давуу эрхийн зөрүү болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендерийн бичиг баримтад тодорхой зааж, тендерийг үнэлэх, харьцуулахад баримтална.

88.Давуу эрхийн зөрүү дор дурдсан хэмжээнээс хэтэрч үл болно:

а)тендерийн Монгол Улсын гарал үүсэлтэй бараа агуулсан хэсгийн үнийг бусад тендерийн тухайн хэсгийн үнэтэй харьцуулахад 10 хувь (Түлхүүр гардуулах гэрээний үед давуу эрхийн зөрүү нь барааны багцад бүхэлд нь бус зөвхөн уг багцад орсон Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд хамаарна);

б)давуу эрхийн шалгуурыг хангасан дотоодын гүйцэтгэгчийн ажлын гэрээний тендерийн үнийг бусад гүйцэтгэгчийн тендерийн үнэтэй харьцуулахад 7.5 хувь.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх олгох

89.Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт бусад бараа санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрх олгож болно. Давуу эрх олгох бол давуу эрхийн зөрүү, давуу эрх эдлэхийн тулд ямар нотлох баримт мэдээлэл ирүүлэхийг тендерийн бичиг баримтад тодорхой заана.

Бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгч аль улсын иргэн болохыг давуу эрх олгоход харгалзахгүй. Давуу эрх олгох тохиолдолд дор дурдсан аргачлалыг мөрдөнө.

90.Харьцуулах зорилгоор шаардлагад нийцсэн тендерүүдийг дараахь байдлаар гурав ангилна:

а)А ангилал: Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендер (Монгол Улсын гарал үүсэлтэй бараа болохыг тендерт оролцогч нотлон харуулах үүрэгтэй);

б)Б ангилал: Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа импортын бараа санал болгосон тендер;

в)С ангилал: Импортоор оруулж ирэх бараа санал болгосон тендер.

91.А ангиллын санал болгосон EXW үндэ дотоодын зах зээлээс худалдан авсан, эсхүл импортоор оруулж ирсэн үндсэн материал, эд ангид төлсөн буюу төлөх албан татварын дүнг оруулна. Б ангиллыг үүнтэй адилаар тооцно. А болон Б ангиллын санал болгосон үнээс эцсийн бүтээгдэхүүнд оногдуулдаг нэмэгдсэн өртгийн болон бусад адилтгах албан татварын дүнг хасна. С ангиллын санал болгосон CIF, CIP үнээс гаалийн татварыг оролцуулан импортын бүх татварын дүнг хасна.

92.Эхний шатанд ангилал тус бүрийн доторхи үнэлэгдсэн тендерүүдийг харьцуулан хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг ангилал бүрээр гаргана. Ангилал тус бүрийн хамгийн сайн үнэлэгдсэн тендерүүдийг хооронд нь харьцуулсны үр дүнд А буюу Б ангиллын тендер хамгийн сайн үнэлэгдсэн тендер бол тус тендерийг ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.



93. Хэрэв энэ журмын 92-т заасны дагуу хооронд нь харьцуулсны үр дүнд С ангиллын тендер хамгийн сайн үнэлэгдсэн тендер бол С ангиллын тендер бүрийн импорттоор оруулж ирэх барааны үнэлэгдсэн үнэ дээр энэ Барааны CIF буюу CIP тендерийн үнийн 10 хувьтай тэнцэх дүнг зөвхөн харьцуулах зорилгоор нэмж А ангиллын хамгийн сайн үнэлэгдсэн тендертэй харьцуулна. Ийнхүү харьцуулахад А ангиллын тендер хамгийн сайн үнэлэгдсэн тендер бол түүнд гэрээ байгуулах эрх олгоно, эсрэг тохиолдолд С ангиллын энэ журмын 92-т заасны дагуу хамгийн сайн үнэлэгдсэн тендерт гэрээ байгуулах эрх олгоно.

94. Барааг бэлтгэн нийлүүлж угсрах болон түлхүүр гардуулах гэрээний үед давуу эрхийн зөрүү нь барааны багцад бүхэлд нь бус зөвхөн уг багцад орсон Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд хамаарна. Импорттоор оруулж ирэх тоног төхөөрөмжид CIF буюу CIP үнэ, дотоодос санал болгох тоног төхөөрөмжид EXW үнэ (номсгдсэн өртгийн болон бусад адилтгах татаварын дүнг үл тооцсон) ирүүлэх ба зураг төсөл, ажил, угсралт, хяналт зэрэг бусад бүх нэр төрлийн үнийг тусад нь ирүүлнэ. Тендерүүдийг энэ тохиолдолд А, Б, С гэж ангилнахгүй. Тендерүүдийг хооронд нь харьцуулах зорилгоор тендер бүрийн импорттоор оруулж ирэх тоног төхөөрөмжийн CIF, CIP үнийг 10 хувиар өсгөнө. Тус багцад орсон холбогдох ажил, үйлчилгээнд давуу эрхийн зөрүү тооцогдохгүй.

Дотоодын гүйцэтгэгчид давуу эрх олгох

95. Ажлын гэрээний үед дотоодын гүйцэтгэгчид 7.5 хувийн давуу эрхийг дараахь шаардлагыг баримтлан олгож болно:

а) шаардлагад нийцсэн тендерүүдийг дараахь байдлаар ангилна:

А ангилал: давуу эрхийн шалгуурыг хангасан дотоодын гүйцэтгэгчийн ирүүлсэн тендер;

Б ангилал: бусад гүйцэтгэгчийн ирүүлсэн тендер.

Харьцуулах зорилгоор Б ангиллын тендерийн үнэ дээр тус тендерийн үнийн 7.5 хувийг нэмнэ.

Ес. Худалдан авах ажиллагааны хавтаст хэрэг

99. Захиалагч худалдан авах ажиллагаа бүрт бичиг баримтын бүрдлийн хавтаст хэрэг нээж хөтлөн, архивын нэгж болгон хадгална. Гэрээний хэрэгжилттэй холбоотой бичиг баримтыг тухайн худалдан авах ажиллагааны хавтас хэрэгт хавсарган хөтөлнө. Худалдан авах ажиллагаа дууссаны дараа дор дурдсан баримтыг зохих журмын дагуу хавтаст хэрэгт бүрдүүлж товъёоглоно. Үүнд:

а) тендерийн урилга болон тендерийн бичиг баримт;

б) тендер шалгаруулалтад ирүүлсэн бүх тендер, түүний дотор шалгарсан тендер;

в) Тендерийн хороо болон үнэлгээний хэсгийн хуралдааны тэмдэглэл, үнэлгээний хүснэгт, албан

б) давуу эрх эдлэхийг хүссэн гүйцэтгэгч өмчлөлийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ. Энэ мэдээллийг дээрх ангиллын дагуу тухайн гүйцэтгэгч буюу хэд хэдэн гүйцэтгэгч эрхийн ангилал дотоодын давуу эрхийн шалгуурыг хангасан эсхийг тогтооход ашиглана. Давуу эрх, түүнийг олгоход мөрдөх аргачлалыг тендерийн бичиг баримтад тодорхой заана.

96. Шаардлагатай тохиолдолд, давуу болон аргачлалыг Сангийн яам гаргаж мөрдүүлнэ.

Дотоодын гүйцэтгэгч

97. Дотоодын гүйцэтгэгч өөрийн тендерийг бусад гүйцэтгэгчийн тендертэй харьцуулахад 7.5 хувийн давуу эрх эдлэх хүсэлтэй бол өөрийгөө дотоодын гүйцэтгэгч болох талаар нотлоход шаардлагатай бүх нотолгоог ирүүлэх үүрэгтэй. Ажлын гэрээний үед захиалагч дотоодын гүйцэтгэгчид 7.5 хувийн давуу эрхийн зөрүүг дараахь шаардлагыг баримтлан олгож болно. Дараахь шаардлагуудыг бүхэлд нь хангасан гүйцэтгэгчийг дотоодын гүйцэтгэгч гэж тооцно. Үүнд:

а) Монгол Улсад бүртгэгдсэн;

б) Монгол Улсын иргэн өмчийн олонхийг буюу бүхэлд нь өмчилдөг;

в) гэрээний үнийн 50-наас илүү хувийг гүйцэтгүүлэхээр гадаадын гүйцэтгэгчтэй туслан гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, цаашид байгуулахгүй.

98. Тухайн тендер шалгаруулалтад оролцохын тулд дотоодын болон гадаадын гүйцэтгэгчид нь талзудын эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан гэрээний үндсэн дээр түншлэл байгуулж болно. Энэхүү түншлэл нь дараахь шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд мөн давуу эрх эдлэнэ:

а) дотоодын түнш(үүд) энэ журмын 97-д заасан шалгуурыг бие даан хангасан;

б) дотоодын түнш(үүд) гэрээний үнийн дунгийн 50-наас илүү хувийг шууд захиран зарцуулах эрхтэйгээр төлбөрт хүлээн авах, энэ талаар нөхцөлийг түншлэлийн гэрээнд заасан байна;

в) гэрээний үнийн 50 хувиас багагүй дүнтэй тэнцэх ажлыг дотоодын түнш гүйцэтгэхээр тендерт тусгасан.

бичиг болон бусад материал, бичиг болон бусад материал;

г) тендер шалгаруулалтын өмнөх уулзалтыг зохион байгуулсан бол түүний тэмдэглэл;

д) тендерт оролцогчоос ирүүлсэн албан бичиг болон түүнд өгсөн хариу;

е) гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэл;

ж) урьдчилсан сонголт болон гэрээ хэрэгжүүлэх чадварыг шалгах журам (хэрэв хэрэгжсэн бол);

з) гарын үсэг зурсан гэрээ, хавсралт болон гэрээний өөрчлөлт;

и) гэрээний хэрэгжилт, хяналт, үнэлгээ болон төлбөртэй холбогдох бичиг баримт;

к) бусад зүйл.

Арав. Бусад зүйл

100. Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд оролцож буй талууд худалдан авах ажиллагааны өс зүйн хэм хэмжээг чанд мөрдөнө.

101. Бэлтгэн нийлүүлэгч буюу гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох болон гэрээ байгуулахдаа авилгал, залилан мэхлэх үйл

ажиллагаанд холбогдсон нь шүүх, эсхүл холбогдох байгууллагаар тогтоогдвол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална. Энэ тохиолдолд түүнд гэрээ байгуулах эрх олгохоос түр хугацаагаар буюу бүрмөсөн татгалзах, энэ тухай нийтэд зарлан мэдэгдэнэ.

Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журмын 1 дүгээр хавсралт

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ҮЕ ШАТ

ТӨСЛИЙН НЭР: _____
ТӨСӨВТ ӨРТӨГ: _____

А. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Үйл ажиллагаа		Үргэлжлэх хугацаа /хоногоор/	
		доод	дээд
1	Захиалагч байгууллага _____		
2	Төслийн № _____		
3	Тодорхойлолт _____		
4	Төсөвт өртөг /батлагдсан зардал _____		
5	Хөрөнгийн эх үүсвэр _____		
6	Техникийн тодорхойлолт /ажлын тоо хэмжээ бэлтгэх _____		
7	Тендерийн бичиг баримт бэлтгэх _____		
8	Тендерийн бичиг баримтыг тендерийн хороонд танилцуулах _____		
9	Тендерийн хороо "Батлах" огноо _____		
10	Зарлан мэдээлэх /тендерийн урилга _____		
11	Тендерийг хүлээн авах эцсийн огноо _____		
12	Тендерийг нээх огноо _____		
	Урьдчилсан шалгалт, тендерийг хадгалах _____		
	Тендерийн баталгаа (шаардлагатай бол) _____		
	Дүн _____		
	Хүчинтэй хугацаа _____		
13	Үнэлгээний хэсэг үнэлгээг дуусгах _____		
14	Гэрээ байгуулах эрх олгох дүгнэлтийг тендерийн хороонд танилцуулах _____		
15	Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл _____		
16	Гэрээнд гарын үсэг зурах _____		
	Гэрээний төслийг бэлэн болгох _____		
	Гарын үсэг зурсан гэрээг хүлээн авах огноо _____		
17	Гүйцэтгэлийн баталгаа хүлээн авах (шаардлагатай бол) _____		
	Хүлээн авах огноо _____		
	Дүн _____		
	Хүчинтэй хугацаа _____		
18	Импортын зөвшөөрөл олгохыг хүсэх (шаардлагатай бол) _____		
	Импортлох зөвшөөрлийг хүлээн авах _____		
19	Аккредитив нээх: _____		
	Аккредитивын дугаар _____		
	Нээсэн огноо _____		
	Дүн _____		
	Хүчинтэй хугацаа _____		
	Төлбөр хүлээн авагчийн банкны нэр _____		


Б. МАТЕРИАЛ ТЕХНИК ХАНГАМЖ

Үйл ажиллагаа		Үргэлжлэх хугацаа /хоноогоор/	
		доод	дээд
20	Тээвэрлэлтийн захиалгыг хянах _____		
21	Барааны тээвэрлэлт _____ Тээврийн бичиг баримтыг хүлээн авах _____ Тээврийн бичиг баримтыг батлах _____ Барааг (байршил) хүргэх огноо _____		
22	Гаалийн бүрдүүлэлт _____ Гаалийн мэдүүлгийг бэлтгэх _____ Гаалийн мэдүүлэг, тээврийн бичиг баримтыг танилцуулах _____ Боомт, буудлын хураамж төлөх г.м _____		
23	Тээвэрлэж агуулахад хүргэх _____ Барааг шалгах _____ Дутагдал бий бол мэдэгдэх _____ Гомдол гаргах (швардлагатай бол) _____		
24	Ажлын талбайд хүргэх, түгээх _____		

Бараа, ажлын гүйцэтгэгч сонгоход баримтлах тусгай журмын 2 дугаар хавсралт

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГРАФИК

Төслийн № _____
Төслийн нэр _____

№	Зорилтууд	2000												2001				
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III	IV	
1.	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА																	
	1.1. Техникийн тодорхойлолтыг бэлтгэх	█	█	█	█	█												
	1.2. Тендерийн бичиг баримтыг бэлтгэх			█	█	█												
	1.3. Тендерийн хороогоор батлуулах																	
	1.4. Тендерийн урилга					█												
	1.5. Тендерийн үнэлгээ																	
	1.6. Батлах																	
	1.7. Гэрээ байгуулах эрх олгох, гэрээнд гарын үсэг зурах						█	█	█	█	█	█						
2.	Материал техник хангамж																	
	2.1. Хүргэх (тээвэрлэх)																	
	2.2. Гаалийн бүрдүүлэлт																	
	2.3. Тээвэрлэлт+В7																	
	2.4. Агуулах																	
	2.5. Хуваарилалт																	
	2.6. Тайлан																	

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БҮЮУ ХУВААРЬ

Төлөвлөгөөг хянах Огноо: _____

Захиалгач _____

Төслийн No. _____

Төслийн нэр _____

Зөвшөөрөгдсөн зардал (Төгрөг)

№	Худалдан авах ажиллагааны үнэ шат	Үйл ажиллагааны төлөвлөгөө			Гүйцэтгэл			Бичиг баримат		Тайлбар
		Эзлэх	Дуусгах	Урьдчилж х түлээ	Эзлэх	Дуусгах	Урьдчилж х түлээ	Дуусгах	дугаар/ нэр	
		он	сар	өдөр	он	сар	өдөр	он	сар	өдөр
	Үйл ажиллагааны жогсаалт									
1.	Төл торраройонт ба аялын тоо эзэмээг бэлтгэх									
2.	Төндрийн бичиг баримтыг бэлтгэх									
3.	Төндрийн бичиг баримтыг батлах: Хүсэлт гаргах									
4.	Төндрийн бичиг баримтыг батлах: Зөвшөөрөх									
5.	Төндрийн урьтга (зарлан мэдээлэх)									
6.	Төндрийг хүлээн авах жэрсийн хугацаа									
7.	Төндөр ий нээх									
8.	Төндрийн хянан үзэх ба үнэлэх									
9.	Гэрээ байгуулах эрх олгохыг батлах: Зөвлөмж гаргах									
10.	Гэрээ байгуулах эрх олгохыг батлах: Зөвшөөрөх									
11.	Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл									
12.	Гэрээнд гарын үсэг зурах									
13.	Гүйцэтгэлийн баталгааг хүлээн авах									
14.	Ймпортлын зөвшөөрөл хүсэх (шаардлагатай бол)									
15.	Аюулдат мэ нээх									
16.	Тээвэрлэлийн захиалгыг явах									
17.	Тээвэрлэлийн захиалга (боомт хүртэл)									
18.	Галсийн бүрдүүлэлт									
19.	Газар (гааршаар)									
20.	Агуулах									
21.	Ажлын талбайд хүргэх/ашигласнад хүлээн авах									

Төндрийн No. _____

Гэрээний өргөг (төгрөг) _____

Тодорхойлолт: _____



Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журмын 5 дугаар хавсралт


БАРАА, ЖИЖИГ ХЭМЖЭЭНИЙ АЖИЛ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БҮДҮҮВЧ



Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журмын 6 дугаар хавсралт

ТОМ ХЭМЖЭЭНИЙ АЖИЛ БОЛОН ТЕХНИКИЙН ЦОГЦОЛБОР БАРАА ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БҮДҮҮВЧ

(УРЬДЧИЛСАН СОНГОЛТЫН ЖУРМЫГ ХЭРЭГЛЭХ ҮЕД)



Бараа, ажлын гүйцэтгэчийг сонгоход баримтлах тусгай журмын 7 дугаар хэвсрэлт

ТЕНДЕРИЙН ХОРООНЫ ХЭЛБЭР, БҮРЭЛДЭХҮҮН

№	Босоо үнэ (төгрөгөөр)		Тендерийн хороо	Бүрэлдэхүүн
	Бараа, үйлчилгээ	Ажил		
1	5'000'001-10'000'000	10'000'001-20'000'000	Сум, дүүрэг, байгууллагын (төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх бол)	Тендерийн хорооны дарга нь захиалгач байгууллагын дарга, эсхүл түүний эрх олгосон албан тушаалтан байна. Уг тендерийн хороо нь санхүүгийн ажилтан, ажлын хувьд техникийн бичиг баримт-бэлтгэх үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн инженер, зөвлөх инженер, бараа худалдах-худалдан авах гэрээний хувьд тухайн асуудал хариуцсан ажилтан болон техникийн шинжээчээс бүрдэнэ.
2	10'000'001-50'000'000	20'000'001-75'000'000	Аймаг, нийслэл, агентлагийн (төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх бол)	Тендерийн хорооны дарга нь аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарга, эсхүл түүний эрх олгосон албан тушаалтан байна. Уг тендерийн хороо нь захиалгач байгууллагын төлөөлөгч, санхүүгийн ажилтан, тухайн асуудлыг хариуцсан нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгч, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажилтан (нийслэл, агентлагийн тендерийн хороо бол), эсхүл санхүүгийн хэлтсийн дарга (аймгийн тендерийн хороо бол), ажлын гэрээний хувьд техникийн бичиг баримт бэлтгэх үүрэгтэй нэг буюу хэд хэдэн инженер, зөвлөх инженер, дэд бүтцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох ажилтан (нийслэл, агентлагийн тендерийн хороо бол), салбар хариуцсан ажилтан (аймгийн тендерийн хороо бол), бараа худалдах-худалдан авах гэрээний хувьд тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн болон техникийн шинжээчээс бүрдэнэ.
3	50'000'001-100'000'000	75'000'001-150'000'000	Яамны (төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх бол)	Яамны Тендерийн хорооны дарга нь тухайн яамны Төрийн нарийн бичгийн дарга, эсхүл түүний эрх олгосон албан тушаалтан байна. Уг Тендерийн хороо нь тухайн яамны санхүүгийн ахлах мэргэжилтэн, захиалгач байгууллагын төлөөлөгч, тухайн ажиллагааг хэрэгжүүлэх нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгч, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтэн, ажлын гэрээний хувьд техникийн бичиг баримт бэлтгэх үүрэг хариуцлага хүлээсэн нэг буюу хэд хэдэн инженер, эсхүл инженерийн зөвлөх компани, дэд бүтцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох ажилтан, бараа худалдах-худалдан авах гэрээний хувьд тухайн асуудал хариуцсан ажилтан болон техникийн шинжээчээс бүрдэнэ.
4	100'000'000 - аас дээш	150'000'001 -ээс дээш	Яам дундын (төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх бол)	Тендерийн хорооны дарга нь төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга, эсхүл түүний эрх олгосон албан тушаалтан байна. Уг тендерийн хороо нь түүний томилсон Засгийн газрын холбогдох яам, агентлагийн ажилтнууд, захиалгач байгууллагын төлөөлөгч болон тухайн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгчөөс бүрдэнэ.
5	5'000'001-ээс дээш	10'000'001-ээс дээш	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажиллагаанд Тендерийн хороог тухайн шатны Засаг дарга байгуулна. Уг тендерийн хороо нь захиалгач байгууллагын төлөөлөгч, санхүүгийн ажилтан, тухайн асуудлыг хариуцсан нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгч, ажлын гэрээний хувьд техникийн бичиг баримт бэлтгэх үүрэгтэй нэг буюу хэд хэдэн инженер, зөвлөх инженер, бараа худалдах-худалдан авах гэрээний хувьд тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн болон техникийн шинжээчээс бүрдэнэ.
6	5'000'001-ээс дээш	10'000'001-ээс дээш	Төрийн өмчийн үйлдвэрийн газрын	Төрийн өмчийн үйлдвэрийн газрын удирдлага Тендерийн хороог байгуулж, түүнд Төрийн өмчийн хорооны ажилтныг оруулна.
7	5'000'001-ээс дээш	10'000'001-ээс дээш	Орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын	Орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын удирдлага Тендерийн хороог байгуулж, түүнд орон нутгийн өмчийн асуудал хариуцсан ажилтныг оруулна.
8	5'000'001-ээс дээш	10'000'001-ээс дээш	50%-иас дээш төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн	Төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол гүйцэтгэх удирдлага) Тендерийн хороог байгуулна.

Санамж: Тендерийн хорооны дарга тендерийн хорооны гишүүдийг томилно. Барааны төсөвт өртөг 5'000'001, ажлын төсөвт өртөг 10'000'001 төгрөгөөс хэтрээгүй тохиолдолд захиалгач байгууллагын дарга худалдан авах ажиллагааг хэрэгжүүлж, гэрээ байгуулах эрх олгоно.

Бараа, ажлын гүйцэтгэлийг сонгоход баримтлах тусгай журмын 8 дугаар хавсралт

БАРАА, АЖИЛ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ БОСГО ҮНЭ, ТҮҮНД ХОЛБОГДОХ ТЕНДЕРИЙН ЖИШИГ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

БАРАА		АЖИЛ	
Барааны төсөвт өртөг	Бараа худалдан авах ажиллагааны жишиг бичиг баримт	Ажлын төсөвт өртөг	Ажил худалдан авах ажиллагааны жишиг бичиг баримт
1 5'000'001- 10'000'000	Бараа бэлтгэн нийлүүлэх, хүргэх, суурилуулах Жижиг хэмжээний бараа худалдан авах Үнийн саналын хүсэлт	10'000'001-20'000'000	Дунд хэмжээний ажлын Жижиг хэмжээний ажлын
2 10'000'001- 50'000'000	Бараа бэлтгэн нийлүүлэх, хүргэх, суурилуулах Бараа худалдан авах Жижиг хэмжээний бараа худалдан авах	20'000'001-75'000'000	Дунд хэмжээний ажлын Жижиг хэмжээний ажлын
3 50'000'001- 100'000'000	Бараа бэлтгэн нийлүүлэх, хүргэх, суурилуулах Бараа худалдан авах	75'000'001-150'000'000	Томоохон хэмжээний ажлын Дунд хэмжээний ажлын
4 100'000'001 -ээс дээш	Түлхүүр гардуулах гэрээ Бараа бэлтгэн нийлүүлэх, хүргэх, суурилуулах Бараа худалдан авах	150'000'001 -ээс дээш	Түлхүүр гардуулах гэрээ Томоохон хэмжээний ажлын Дунд хэмжээний ажлын

Санамж: Харьцуулалт, шууд гэрээ байгуулахад жижиг хэмжээний бараа, ажил худалдан авах тендерийн жишиг бичиг баримтыг ашиглаж болно.

Бараа, ажлын гүйцэтгэчийг сонгоход баримтлах тусгай журмын 9 дүгээр хавсралт

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ЖИШИГ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

Төрөл	Жишиг бичиг баримт
Бараа худалдан авах тендерийн бичиг баримт	Бараа худалдан авах Бараа худалдан авах (жижиг гэрээ) Бараа бэлтгэн нийлүүлэх, хүргэх, суурилуулах Саналын хүсэлт (харьцуулалт ба шууд гэрээ байгуулах үед)
Ажил худалдан авах тендерийн бичиг баримт	Түлхүүр гардуулах гэрээ Томоохон хэмжээний ажлын Дунд хэмжээний ажлын Жижиг хэмжээний ажлын (харьцуулалт ба шууд гэрээ байгуулах үед)
Худалдан авах ажиллагааны жишиг бичиг баримт	Бараа, ажлын тендерийн үнэлгээний заавар Жижиг бараа, ажлын тендерийн үнэлгээний заавар Урьдчилсан сонголтын жишиг бичиг баримт
Жишиг журам	Гүйцэтгэчийн бүртгэлийн журам
Бусад	Шаардлагатай үед

Санамж: Хуулийн дагуу явагдах бүх гэрээнд мөрдөх жишиг бичиг баримт болон үлгэрчилсэн гэрээний маягтыг Сангийн яам баталж гаргана. Захиалагч эдгээр бичиг баримт, маягтыг мөрдөх үүрэгтэй.

Төгсгөл нь дараагийн дугаарт

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргаж,
Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

329612
 Идэкс 14003

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг
эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт
хэвлэв.

327806,
320407